Ерөнхий Хураангуй

Дараах ерөнхий хураангуйд ХШБ-ийн олж тогтоосон зүйлсийн талаар ажлын удирдамж болон хийсэн судалгааны хүрээнд аль болох товч дүгнэлт өгөхийг зорилоо. Эдгээр зүйлсийг тайлангийн дараагийн хэсгүүдэд нэгбүрчлэн дэлгэрүүлсэн болно.

Ажлын удирдамжийн заалтуудыг дор жагсаан тэдгээртэй холбоотой олж тогтоосон зүйлсийг ард нь орууллаа. ХШБ-ийн ажлын тухайд лавлах, хэлэлцэх зүйл байвал дуртайяа хүлээж авах болно.

Олж тогтоосон зүйлс

А) **Ундай голын үндсэн урсгалыг өөрчилсөн талаар, тухайлбал:**

- *Ундай голын үндсэн урсгалыг өөрчлөх зураг төсөл болон барилгын ажил нь Ундай гол малчдын хэрэгцээг өмнө нь хангаж байсан шиг хэмжээний, чанартай усаар хангахаар хийгдэж чадсан эсэх;*
- *Ундай голын үндсэн урсгалын өөрчлөлтөөс үүдэн малчдын бэлчээр, усны хангамж болон усны чанарт учирч буй шууд, шууд бус, хам нөлөө; түүнчлэн*
- *Ундай голын үндсэн урсгалын өөрчлөлт болон малчдын бэлчээр, усны хангамж, усны чанарт нөлөө үзүүлэхгүй байх/эсвэл нөлөөг багасгах тохиромжит өөр хувилбарууд, өөрчлөлтүүд болон/эсвэл үүнтэй холбоотой мониторингийн болон нөлөөллөөс зайлсхийх эсвэл нөлөөллийг бууруулах төлөвлөгөө.*

Уурхайн барилгын ажилд ус ашигласан, ус шавхсан болон ил уурхайн улмаас гүехэн гүний ус доошилсон байна. Ундай голын аллювын хурдас ус нэвчих үе давхаргатай холбоотой нь илэрхий тул ил уурхайн хонхор цүнхэлийн орчим гүехэн гүний ус доошилсноор Ундай голын аллювын хурдас, Бор Овоогийн задгайн ус Ундай голоос 1-2 км газарт алдагджээ. (Смит, 2013; хуудас 10, 39)[1].

Нүүрсний зам болон төмөр замын барилгын ажилд ус авч ашигласан, ус зайлуулах байгууламж муугаас үерийн урсгал болон Ундай голын ай савын ундаргад нөлөөлжээ. Энэ нь хэдийгээр ОТ-н уурхайн үйл ажиллагаа эсвэл Ундай голын өөрчлөлттэй шууд холбоогүй ч ХШБ-ийн 1-р шатны Тайланд малчдын усны эх үүсвэр, бэлчээрийн хуваагдлын хам нөлөөллийн дүн шинжилгээний нэг хэсэг болгон авч үзсэн болно.

Ундай голын үндсэн урсгалыг өөрчилснөөр малчдын усны хүрэлцээнд учруулсан хамгаас илт, шууд нөлөө бол үе үе тохиох үерээр Ундай голын гольдролын өөрчилсөн хэсгийн дагуу Ундай голын гадаргын усанд хүрч чадахгүй болсон явдал юм. Шинэчлэн өөрчилсөн сувгийн ойр орчимд аллювын томхон ай сав байхгүй -- эх урсгалын аллювын ай савын зарим хэсэгт хонхор цүнхэл нөлөөлсөн зэргээс Ундай голын аллювын уст давхаргын гүний ундрага эдгээр үерээр тэтгэгдэхгүй болсон нь бас нэг нөлөөлөл учруулжээ.

Далан болон үндсэн урсгалын өөрчлөлтийн зургийг гаргахдаа ашигласан загварт (бороо хур/урсац) үерын усны бодит урсацыг урьдчилан тооцсон эсэх нь тодорхойгүй ба Ундай голын гадаргын урсацыг хэмжих, загварыг гаргахын тулд нэмэлт мэдээлэл хэрэгтэй (Смит, 2013).

---

[1] Смит, Г. 2013: Оюу Толгой, Уурхай орчмын гидрологийн нөхцөл байдал, ОТ ХХК-д зориулсан Акуатерагийн тайлан

Б) Бор Овоогийн задгайг шилжүүлэхээр төлөвлөсөн байршлийн талаар, тухайлбал:

- *Бор Овоогийн Задгайг нүүлгэн шилжүүлэхээр санал болгосон хийц загварын зохимжит байдал болон өмнө байсан задгайн экологи, соёл, нийгэмд гүйцэтгэж буй үүргийг илүүтэй орлож чадахуйц өөр хувилбарууд болон өөрчлөлтүүд*
- *Бор Овоогийн Задгайг нүүлгэн шилжүүлснээр малчдын бэлчээр, усны хангамж болон усны чанарт учирч буй шууд, шууд бус, хам нөлөө.*

Бор Овоогийн задгайг нүүлгэснээр малчдын усны хүрэлцээ, усны чанарт учруулсан шууд нөлөө бол задгай бүрмөсөн үгүй болсон явдал юм
Уурхайн лицензит талбайн (УЛТ) хашааны өмнөд хэсэг дэх усны **түр** эх үүсвэр усаар хангаж байгаа хэдий ч энэ нь Бор Овоон задгайн мал маллагаа болон зэрлэг ан амьтанд үзүүлж байсан экологийн үйлчлэлүүдийн аль алиныг нь нөхөж чадахгүй байна. **Бор Овоон задгай үгүй болсноор малчид шилжүүлэн байршуулсан хоолойгоор гарч буй усанд малаа хүргэхийн тулд урт зам туулах болсон;** УЛТ-г сүүлийн байдлаар хашаалснаас хойш бүр ч их зам туулах болжээ. Мөн түүнчлэн сүүлийн үед үерийн урсац цөөрснөөр малчдын худгийн усны ундрага багасч голын дагуу нутагладаг малчдад нөлөөлж байна.

Ундай голын дагуух малчдын худгууд болон ил усны (задгай) ундарга сүүлийн жилүүдэд багасч байгаа талаарх малчдын ажиглалтыг энэ тайланд дэлгэрэнгүй тусгасан болно. 2014 оны 10 сард ХШБ газар дээр ажиллах үеэр Ундай гол дахь ил ус гэвэл зөвхөн "Хуурт"-ын задгайн багахан ус байлаа.

ОТ уурхай болон дэд бүтцийн барилгын ажил (нүүрсний замыг оролцуулан) усны хагалбарт өргөнөөр нөлөөлснөөр зуны бэлчээрийн хүрэлцээ, усны эх үүсвэр алдагдаж, Ханбогд сумын ялангуяа Жавхлант багийн уламжлалт нүүдлийн мал маллагааны хэмнэлийг ноцтойгоор, эргэлт буцалтгүй бусниулан, нийт малчин түмэнд нөлөөлөл учруулж байна. Ус бэлчээр хайхын зэрэгцээ өвлийн бэлчээрээ өнжөөн амрааж чадахгүй байгаагаас бусад бэлчээрийн газар мөн доройтож байна. Түүнчлэн бэлчээрийн хуваагдал, механик эвдрэл гэмтэл, тоос шороо, дэд бүтцийн дагуух хог хаягдал зэргээс үүдэлтэй хам нөлөөллүүд нэлээд ноцтой байгаа бөгөөд уурхайн бүтээн байгуулалт өрнөхийн хэрээр үргэлжлэн нэмэгдэх билээ.

Усны чанарын мониторингийн үзүүлэлтээс харахад үндсэн урсгалыг өөрчилсөн хэсгийн дээд болон доод талд аллювын гүехэн гүний усны чанар сайн, эрдэсжсэн ул чулуулгатай хүрэлцсэний улмаас **бохирдсныг гэрчлэх зүйл байхгүй байна.** (сар тутмын Мониторингийн Тайлан, #34, 2014 оны 12 сар). Усны чанарын мониторингоор хоолойноос гарч буй усны чанар сайн гэсэн хэдий ч **мал амьтан ирж ундаалж/ малын ялгадас хуримтлагдсанаас хоолойноос доош усны чанар муудаж байна (хүчиллэг байдал, ууссан хатуу биетийн нийт хэмжээ, цахилгаан дамжуулах чанар, сульфат, хлор ихэссэн).**

УЛТ-аас айл өрхүүдийг нүүлгэн суурьшуулснаас болж бэлчээрийн үржил шим алдагдан, нөлөөлөлд өртсөн өрхүүдийн хувьд бэлчээрийн ачаалал

нэлээд ихэссэн (Бодлого Судлалын Төв /БСТ/, 2012 б)[2] бөгөөд усны эх үүсвэрийн асуудал энэ байдлыг улам хүндрүүлж байна.

Одоо байгаа суурь мэдээлэл хангалтгүй тул үндсэн урсгал өөрчилсний улмаас учирсан нөлөөллийг төслийн бусад үйл ажиллагааны үр дагавраас ялгах боломжгүй. Ундай голын дагуу ургадаг малын тэжээлийн өвс ургамлын төрөл зүйлийн бүрэлдэхүүн өөрчлөгдсөн нь хуурайшилт, бэлчээрийн доройтлыг илэрхийлнэ. Сүүлийн арван жилийн цаг агаарын мэдээнээс үзэхэд хур тунадасны жилийн дундаж хэмжээ бага зэрэг нэмэгдсэн, нэлээд хэдэн жил өмнөх жилүүдээс онцгой илүү бороо хур орсныг баримтжуулжээ. Цаг уурын өөрчлөлтөнд Говийн бэлчээрийн ургамлын үзүүлэх хариу үйлдэл нарийн төвөгтэй; төслийн нөлөөлөлд өртсөн бүс дэх ургамалжилтын доройтлыг юуны түрүүнд цаг уурын өөрчлөлттэй холбон дүгнэж болохгүй.

[2] Бодлого Судлалын Төв, 2012 б: Ханбогд сумаас Нүүлгэлтийн Хөтөлбөрт хамрагдсан малчин өрхүүдийн бэлчээрийн хүрэлцээ, чанарт гарсан өөрчлөлтийн үнэлгээ